СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2023 | V

СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2023
5 сар

Баруун-Урт сум

Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон үгийн тайлал.

- Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

- ‘Төл’ гэсэн нь төлөвлөгөө, ‘Гүйц’ гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав)

III. Дараах тэмдэглэлийг ашиглав.

...	Мэдээлэл байхгүй	-	Гүйцэтгэл байхгүй
0.0	Маш бага тоо	*	Урьдчилсан гүйцэтгэл
¹	Дахин		
a^x	x нь өмнөх оны мөн үетэй харьцуулсан цэвэр өсөлт, бууралтын хувь		
▲▼	эерэг хандлага, эерэг өөрчлөлт	▲▼	сөрөг хандлага, сөрөг өөрчлөлт

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ.

• мянга	=1000	• $м^2$	метр квадрат
• сая	$=10^6$	• $км^2$	километр квадрат
• тэрбум	$=10^9$	• $м^3$	метр куб
• см	сантиметр	• мл	миллилитр
• дм	дециметр	• л	литр
• м	метр	• г	грамм
• км	километр	• кг	килограмм
• мян.	мянга	• цн	центнер
• %	хувь	• т	тонн
• кВт.ц	киловатт цаг	• ш	ширхэг
• ккал	килокалори		

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл 2

Үндсэн үзүүлэлтүүд 5

I Хүн ам 6-7

II Нийгмийн халамж 8

III Эрүүл мэнд 9-11

IV Гэмт хэрэг 12-14

V Мөнгө, банк 15-16

VI Орон нутгийн төсөв 17

VII Үнэ 18-20

VIII Хөдөө аж ахуй 21-25

IX Аж үйлдвэр 26-28

Хавсралт хүснэгтийн жагсаалт 33-34

Хавсралт хүснэгтүүд 34-60

БҮЛЭГ	ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:
Үндсэн үзүүлэлтүүд /Хүснэгт/	Э.Анхцэцэг
I Хүн ам	Э.Анхцэцэг
II Нийгмийн халамж	Э.Анхцэцэг
III Эрүүл мэнд	Э.Анхцэцэг
IV Гэмт хэрэг	Э.Анхцэцэг
V Мөнгө, Банк	Э.Анхцэцэг
VI Орон нутгийн төсөв	Т.Эрдэнэбат
VII.а Хэрэглээний үнэ	Э.Анхцэцэг
VII.б Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	С.Мөнхбаяр
VIII Хөдөө аж ахуй	С.Мөнхбаяр
IX Аж үйлдвэр	Э.Анхцэцэг

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

Э.Анхцэцэг

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2021 I-V	2022 I-V	2023 I-V
Төрсөн хүүхэд	хүн	585 8.3	410 -29.2	545 32.9
Нялхасын эндэгдэл	хүн	1 83.3	5 5.0**	3 -40.0
Халдварт өвчнөөр өвчдөгчид	хүн	435 2.0**	3 517 80.9 **	562 -84.0
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	158 -33.1	274 73.4	219 -20.1
Хэрэгт холбогсод	хүн	100 -25.4	217 2.2**	98 -54.8
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	103.9 -0.3	106.4 2.4	104.1 -2.2
Иргэдийн хадгаламж	тэрбум төгрөг	150.4 58.0	141.2 -6.1	140.0 -0.8
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум төгрөг	142.4 8.1	192.8 35.4	202.8 5.2
Орон нутгийн төсвийн орлого	тэрбум төгрөг	30.0 0.4	27.6 -8.0	33.1 19.9
Орон нутгийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	29.2 3.5	24.9 -14.7	18.5 -25.7
Төллөсөн хээлтэгч	тол	1352931 0.4	1524772 12.7	1517285 -0.5
Ингэ	тол	902 -21.1	1161 28.7	1046 -9.9
Гүү	тол	61556 5.3	77470 25.9	75413 -2.6
Үнээ	тол	65502 6.4	82249 25.6	78452 -4.6
Эм хонь	тол	764207 0.2	865267 13.2	874503 1.1
Эм ямаа	тол	460764 -0.7	498625 8.2	487871 -2.1
Бойжуулсан төл	тол	1344090 0.7	1515943 12.8	1108419 -26.8
Ботго	тол	888 -21.8	1152 29.7	993 -13.8
Унага	тол	61027 5.6	77055 26.3	59296 -23
Тугал	тол	64984 6.6	81793 25.9	64331 -21.3
Хурга	тол	760756 0.6	861572 13.3	642388 -25.4
Ишиг	тол	456435 -0.5	494371 8.3	341411 -30.9
Том малын зүй бусын хорогдол	тол	37258 18.2	10098 -72.9	552216 54**
Тэмээ	тол	23 43.8	21 -8.7	92 4**
Адуу	тол	1448 24.2	1187 -18	25405 21**
Үхэр	тол	3520 51	1160 -67	28219 24**
Хонь	тол	15214 -3.8	3727 -75.5	260468 69**
Ямаа	тол	17053 39.9	4003 -76.5	238032 59**
Үүнээс: Өвчнөөр хорогдсон мал	тол	-	119	83 -30.2
Үхэр	тол	5	21	-
Хонь	тол	-	45	83 84.4
Ямаа	тол	-	53	-
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	45.4 -4.4	46.6 2.6	85.8 84.2
Борлуулсан бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	108.7 68.6	105.5 -2.9	197.2 86.9

Тайлбар: ** дахин

ХҮН АМ, жил бүрийн эхний 5 сард



Төрсөн хүүхдийн тоо өмнөх оноос 32.9 хувиар өсчээ.

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээлээр 2023 оны эхний 5 сард 542 эх амаржиж, 545 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оноос амаржсан эх 131 (31.9%)-аар, төрсөн хүүхэд 135 (32.9%)-аар тус тус өсчээ.

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 5 сард



1000 хүнд ногдох төрөлт өмнөх оноос 2.1 нэгж хувиар өссөн байна.

ЗУРАГ 2. НАС БАРАЛТ, жил бүрийн эхний 5 сард



2023 оны эхний 5 сард нас баралт 142 болж, өмнөх оноос 7 (5.2%)-аар өсчээ. 1000 хүнд ногдох төрөлт 8.3, нас баралт 2.2, ердийн цэвэр өсөлт 6.1 байна.
1000 хүнд ногдох нас баралт өмнөх оноос 0.1 нэгж хувиар өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн амын ердийн цэвэр өсөлт нь төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ өмнө оноос 2128 (68.9%) хүнээр буурчээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 2023 оны эхний 5 сард нийгмийн халамжийн тэтгэвэрт 1360 хүн хамрагдсан нь өмнөх оноос 47 (3.6%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 1933.9 сая төгрөг болж 118.4 (6.5%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2023 оны эхний 5 сард 2130 хүн хамрагдсаны 50.4 хувь нь асаргааны тэтгэмжид, 49.6 хувь нь онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн тэтгэмжид 855.9 сая төгрөг олгосон нь өмнөх оноос 14.8 (1.8%) сая төгрөгөөр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр, жил бүрийн эхний 5 сар

Үзүүлэлт	2021 I-V		2022 I-V		2023 I-V	
	Хүний тоо	сая төгрөг	Хүний тоо	сая төгрөг	Хүний тоо	сая төгрөг
Бүгд	**25 298**	**4 344.3**	**24 098**	**4 741.4**	**22 792**	**5 635.7**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	8 988	2 944.3	6 518	2 831.4	4 499	2 874.5
Нийгмийн халамжийн тэтгэвэр	1 256	1 804.2	1 313	1 815.5	1 360	1 933.9
Нийгмийн халамжийн тэтгэмж	1 993	797.2	2 084	841.1	2 130	855.9
Нийгмийн халамжийн үйлчилгээ	1	1.4	50	30.5	47	37.7
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	5 739	342.9	3 090	144.3	962	47.0
Алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал	5 236	698.7	5 347	704.5	5 568	722.2
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	4 291	71.8	4 569	141.9	4 594	169.4
Алдар цолтон амхад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	-	-	2	0.3	5	595.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	297	42.4	285	44.7	336	71.0
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	3 804	370.4	4 541	794.8	4 699	957.4
Насны хишиг	2 682	216.7	2 836	223.8	3 091	245.6

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан хүний тоо буурсан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрхийг тодорхойлох журмаа өөрчилсөнтэй холбоотой.

ЭРҮҮЛ МЭНД, жил бүрийн эхний 5 сард

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид

2022 I-V 6 829

2023 I-V 7 048

2.9% ↑

Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид

2022 I-V 3 517

2023 I-V 562

84.0% ↓

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2022 I-V	5
	2023 I-V	3
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2022 I-V	4
	2023 I-V	3

Эхийн эндэгдэл гараагүй.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр 2023 оны эхний 5 сард 542 эх амаржсан нь өмнөх оноос 131 (31.9%)-аар өссөн байна. Нийт амаржсан эхийн 0.6 хувь нь гэртээ төрсөн байна.

Нийт амьд төрсөн хүүхдийн 514 (94.3%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амалсан, 13 (2.4%) нь 2500 граммаас бага жинтэй байна.

ХҮСНЭГТ 2. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, жил бүрийн эхний 5 сард

Үзүүлэлт	2022 I-V	2023 I-V	2023 I-V / 2022 I-V
	тоо		хувь
Амаржсан эх	411	542	131.9
6 түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	376	528	140.4
Гэрийн төрөлт	2	3	150.0
Амьд төрсөн хүүхэд	514	514	100.0
1 цагийн дотор хөхөө амалсан хүүхэд	376	413	109.8
Төрөлхийн гажигтай төрсөн	1	3	3.0 [1]
2500 граммаас доош жинтэй төрсөн	15	13	86.7
Амьгүй төрсөн хүүхэд	3	2	66.7
Амьгүй төрөлтийн түвшин / 1000 нийт төрөлтөд ногдох/	9.8	5.5	56.1

2023 оны эхний 5 сард нас баралтын 142 тохиолдол бүртгэгдсэний 29 (20.6%) нь осол гэмтлийн улмаас, 30 (21.1%) нь хорт хавдарын өвчлөлийн улмаас нас барсан байна.

ХҮСНЭГТ 3. НАС БАРАЛТ, зарим үзүүлэлтээр, жил бүрийн эхний 5 сард

Үзүүлэлт	2022 I-V	2023 I-V	2023 I-V / 2022 I-V
	тоо		хувь
Нас баралт	135	142	105.2
Эмнэлгийн нас баралт	34	23	67.6
Осол гэмтэлийн өвчлөл нас баралт	11	29	2.6 [1]
Хорт хавдрын өвчлөл нас баралт	30	42	140.0
0-1 насны эндэгдэл	5	3	60.0
1-5 хүртэлх насны эндэгдэл	4	3	75.0

Халдварт өвчнөөр өвлөгчид 2023 оны эхний 5 сард 562 болж, өмнөх оны мөн үеэс 2955 (84.0%)-аар буурахад короновируст халдварын тохиолдол буурсан нь нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, өвчний төрлөөр, жил бүрийн эхний 5 сар

Халдварт өвчин	2021 I-V	2022 I-V	2023 I-V	Өсөлт	
	хүн			тоо	хувь
Бүгд	**435**	**3 517**	**562**	**-2 955**	**16.0**
Вируст гепатит	3	2	2	0	100.0
Гар хөл амны өвчин	19	1	106	105	106.0 [1]
Бруцеллёз	-	1	-	-	-
Цусан суулга	12	2	2	0	100.0
Салхинцэцэг	3	5	175	170	35.0 [1]
Энтервируст халдвар	-	-	77	-	-
Гахай хавдар	-	-	2	-	-
Улаан эсэргэнэ	-	-	12	-	-
Ёлом	-	-	1	-	-
Салмонеллт	-	-	1	-	-
Толбот чичрэг	-	-	4	-	-
Сүрьеэ	26	32	32	0	100.0
Тэмбүү	31	15	15	0	100.0
Трихомониаз	36	36	29	- 7	80.6
Заг	31	21	21	0	100.0
Ковид-19	274	3 402	83	-3 319	2.4

Харин салхин цэцгээр өвчлөгчид 170 (35.0 дахин)-аар, гар хөл амны өвчин 105 (106.0 дахин)-аар нэмэгдэж, Коронавируст халдвараар өвчлөгчид 3319 (97.6%)-гөөр буурсан байна. Шинээр энтервируст халдвар 77, улаан эсэргэнэ 12, ёлом 1, салмонеллт 1 өвчний халдварын тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 5 сарын байдлаар 117.2 мянган хүнд үзлэг хийсэн нь урьд оны мөн үеэс 11.3 (10.7%) мянган хүнээр өсч, 7.0 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 24.2 мянган хүн хамрагдсан нь урьд оны мөн үеэс 3.1 (14.7%) мянган хүнээр өсчээ.

Түргэн тусламжийн дуудлага 7.0 мянган удаа гарсны 1.3 (18.6%) мянга нь алсын дуудлага байна.

Ойлголт, тодорхойлолт:

1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

ГЭМТ ХЭРЭГ, 2023 оны эхний 5 сард

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

2022 I-V	2023 I-V	
274	219	-20.1% ↓

Хөнгөн хэрэг
178

Хүнд хэрэг
41

Илрүүлэлтийн хувь
27.4%

Гэмт хэргийн улмаас

Гэмтсэн хүн
55

Нас барсан хүн
9

Хохирол сая төг
580.5

Гэмт хэрэг үйлдэгсэд

Бүлгээр
9

Согтуугаар
53

Ял шийтгэгдэж байсан
17

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос 55 (20.1%)-ээр буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 9 хүн нас барж, 55 хүн гэмтэж бэртсэн бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 580.5 сая төгрөгийн хохирол учирсны 5.5 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 98 хүн холбогдон сэжиглэгдсэний 53 (54.1%) хүн нь согтуугаар хэрэг үйлджээ. Нийт 235 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 58 (32.8%) хүнээр өссөн байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 104 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 27.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 13.9 нэгжээр буурсанн байна.

Зураг 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО



Ойлголт, тодорхойлолт

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр: Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ


МӨНГӨ, ЗЭЭЛ, 2023 оны эхний 5 сард
Нийт зээлдэгчийн тоо
2022 V 29 783
2023 V 32 298
Зээл 2023 V
Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 202.8 тэрбум төгрөг
2.1 тэрбум төгрөг Анхаарал хандуулах зээлийн өрийн үлдэгдэл
1.4 тэрбум төгрөг Чанаргүй зээл
ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ 2023 V
Иргэдийн 110.9 тэрбум төгрөг
Хугацаатай 121.7 тэрбум төгрөг
Хугацаагүй 18.3 тэрбум төгрөг
BANK
Салбар нэгжийн тоо 35
АТМ-ны тоо 30
Ажилтнуудын тоо 210
Карт эзэмшигчийн тоо 63 384

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл эхний 5 сарын байдлаар 1.4 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.7 хувийг эзэлж байна.

Монгол банкны мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 202.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 1.2 (0.5%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 10.0 (5.2%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 140.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 2.6 (1.8%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 1.2 (0.8%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна. Нийт хадгаламжийн 86.9% нь хугацаатай, 13.1 % нь хугацаагүй хадгаламж байна.

Зураг 6. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, ХАДГАДАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр: Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбар, Банкны салбарын мэдээ

Орон нутгийн төсвийн орлого өмнөх оноос 19.9 хувиар өсчээ.

Аймгийн төсвийн нийт орлого 2023 оны эхний 5 сарын байдлаар 33.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 5.5 (19.9%) тэрбум төгрөгөөр өсч, төсвийн зарлага санхүүжилт 18.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 6.4 (25.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 7. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төг



Аймгийн нийт төсвийн 43.2 хувийг орон нутгийн төсвийн орлого, 10.4 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 8.7 хувийг аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, 15.5 хувийг орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг, 19.3 хувийг урьд оны үлдэгдэл, 2.8 хувийг төсөвт байгууллагуудын өөрийн орлого тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт

Төрийн санхүү: Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ.

Эх үүсвэр: Аймгийн төсвийн мэдээг Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгээ боловсруулсан аймгийн төсвийн мэдээ.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, бүлгээр, хувиар

2023 оны 5 дугаар сард



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.8 хувиар өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 5 дугаар сард аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 9.6 хувь, өмнөх оны эцсээс 4.1 хувь, өмнөх сараас 0.8 хувиар өссөн байна.

ЗУРАГ 8. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 5 дугаар өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 16.6 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 7.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 10.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 13.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.5 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 1.6 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 11.4 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 11.3 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.8 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 16.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 5 дугаар сард өмнөх оны эцсээс 4.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 3.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 1.5 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 3.7 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 9.2 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 7.0 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ 12.8 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 5 дугаар сард өмнөх сараас 0.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 1.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 1.1 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 1.0 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны

үйлчилгээний бүлгийн үнэ 6.6 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 5. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2023 оны 5 дугаар сард

Бараа үйлчилгээний бүлэг	2023 V / 2022 V	2023 V / 2022 XII	2023 V / 2023 IV
Ерөнхий индекс	**109.6**	**104.1**	**100.8**
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	116.6	107.9	101.4
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	107.4	102.7	100.0
Хувцас, бөс бараа, гутал	110.1	103.7	101.2
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	103.1	101.5	101.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	113.7	103.7	100.5
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	112.5	109.2	101.0
Тээвэр	101.6	98.3	99.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.2	100.2	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	111.4	103.5	100.5
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	111.3	107.0	106.6
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	112.8	112.8	100.0
Бусад бараа, үйлчилгээ	116.1	104.3	100.6

ЗУРАГ 9. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2023 оны 3 дугаар сард өмнөх сараас 5.1 хувиар өсөхөд хонь, ямааны махны үнэ дунджаар 11.5 хувь, үхрийн махны үнэ 1.4 хувь, адууны махны үнэ 7.0 хувиар тус тус өссөн байна. Харин өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар буурахад үхрийн махны үнэ 3.0 хувь, тахианы махны үнэ 10.0 хувь, адууны махны үнэ 11.2 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Ойлголт, тодорхойлолт

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд нас гүйцсэн малаас хязаалан гунан үхрийн үнэ хамгийн өндөр буюу 1.5 сая төгрөг байна.

Малын зах зээлийн дундаж үнийн 2023 оны 05 дугаар сарын мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад атны үнэ 1.1 сая төгрөг болж, 125 мянган төгрөгөөр, соёолон үрээний үнэ 0.9 сая төгрөг болж, 43.6 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 202.3 мянган төгрөг болж, 10.0 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 130.8 мянган төгрөг болж, 27.7 мянган төгрөгөөр тус тус буурсан байна. Харин хязаалан гунан үхрийн үнэ 1.5 сая төгрөг болж, 31.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

ЗУРАГ 10. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 4 сард, мянган төгрөг



Хязаалан гунан үхрийн үнэ 2023 оны 05 дугаар сард Уулбаян суманд хамгийн их буюу 2.2 сая төгрөг, Баяндэлгэр суманд хамгийн бага буюу 950.0 мянган төгрөг байна.

ЗУРАГ 11. ХЯЗААЛАН ГУНАН ҮХРИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2023 оны 5 сард, мянган төгрөг

Хивэгний үнэ 2023 оны 5 дугаар сард 31.7 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулхад хивэгний үнэ 13.7 мянган төгрөгөөр өссөн бол 1 боодол өвсний дундаж үнэ 22.5 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 17.8 мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 12. ӨВС, НООЛУУРНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 5 сард



Ойлголт, тодорхойлолт:

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, аймгийн худалдааны цэг, ченжүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

МАЛ АЖ АХУЙ 2023 оны эхний 5 сард





Мал төллөлт аймгийн хэмжээнд 73.5 хувьтай байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2023 оны 5 дугаар сарын байдлаар оны эхний төллөх насны 2063.7 мянган хээлтэгч малын 1517.3 мянга (73.5%) нь төлөжээ. Гүүний 58.9 хувь, үнээний 58.2 хувь, ингэний 34.1 хувь, эм хонины 77.4 хувь, эм ямааны 73.1 хувь нь төллөсөн байна.

ЗУРАГ 13. ХЭЭЛТЭГЧ МАЛ, ТӨЛИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, мянган толгой



Бойжуулсан төл 2023 оны 5 дугаар сарын байдлаар 1.1 сая болж, бойжилтын хувь 72.9% байна. Гарсан унаганы 78.6 хувь, тугалын 82 хувь, ботгоны 94.9 хувь, хурганы 73.3 хувь, ишигний 69.8 хувь нь бойжжээ.

Аймгийн хэмжээнд 412021 толгой төл мал хорогдсоноос унага 16117 толгой, тугал 14123 толгой, ботго 53 толгой, хурга 233787 толгой, ишиг 147941 толгой төл мал хорогдоод байна.

Оны эхний малын 11.9 хувь буюу 552.2 мянган толгой том мал 2023 оны эхний 5 сарын байдлаар зүй бусаар хорогдлоо.

ЗУРАГ 14. ХОРОГДСОН МАЛЫН ТОО, сумаар, мянган толгой



Хорогдолыг малын төрлөөр авч үзвэл 20.2 мянган толгой адуу, 24.1 мянган толгой үхэр, 87 толгой тэмээ, 244.2 мянган толгой хонь, 219.7 мянган толгой ямаа байна. Нийт хорогдсон малын 405.8 (79.8%) мянган толгой мал нь аюулт үзэгдэлээр хорогдсон байна.

Ойлголт, тодорхойлолт:

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2023 оны 5 дугаар сарын байдлаар

Уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг



Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум төгрөг

Цахилгаан хий, уур, агааржуулалт, тэрбум төгрөг

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулахболон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөг

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх сараас 43.9 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2023 оны эхний 5 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 85.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 39.2 (84.2%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай олборлолт 33.8 (92.3%) тэрбум төгрөг, боловсруулах үйлдвэрлэл 4.5 (3.2 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 15. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сараар, сая төгрөг



Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2023 оны эхний 5 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 70.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 33.8 (92.3%) тэрбум төгрөгөөр өсөхөд чулуун болон хүрэн нүүрс олборлолт 9.5 (14.0 дахин) тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт 17.9 (64.5%) тэрбум төгрөгөөр, бусад ашигт малтмал олборлолт 6.5 (79.1%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт хүрэн нүүрс, цайрын баяжмал, хайлуур жоншны баяжмалын олборлолтын биет хэмжээ1.0 хувиас 5.4 дахин өсөж, харин хайлуур жонш өмнөх оноос 11.4 хувиар буурчээ.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт талх, хэвийн боов, бялуу, малын мах, гутал зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.9 хувиас 6.3 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ 6. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2022 V	2022 I-V	2023 V	2023* I-V	2023* I-V / 2022 I-V
		тоо				хувь
Уул уурхай, олборлох аж үйлдвэр						
Хүрэн нүүрс	мян.т	-	31.9	58.3	172.1	5.4 [1]
Цайрын баяжмал	мян.т	7.3	31.5	5.8	31.8	101.0
Хайлуур жонш	мян.т	0.8	4.5	0.6	4.0	88.6
Хайлуур жоншны баяжмал	мян.т	1.0	5.2	3.5	9.6	183.9
Боловсруулах аж үйлдвэр						
Талх	т	43.0	186.5	54.5	236.0	126.5
Нарийн боов	т	6.7	38.8	7.0	31.3	80.8
Хэвийн боов	т	0.4	27.3	1.0	45.3	165.9
Бялуу	т	0.8	3.0	0.6	3.1	101.9
Хэрчсэн гурил	т	5.1	32.2	7.4	31.7	98.3
Малын мах	т	57.1	115.0	99.6	354.7	3.1 [1]
Цэвэр ус	мян.л	86.3	418.9	58.9	304.4	72.7
Бууз, банш	т	2	6.5	5.2	9.8	150.0
Монгол дээл,тэрлэг	ш	138	1 033	152	1 010	97.8
Бэлтгэлийн хувцас /өмд, цамц/	ш	-	-	-	15	-
Гутал	хос	5	46	11	290	6.3 [1]

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2023 оны эхний 5 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 197.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 91.5 (86.6%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлолтын салбарын борлуулалт 86.7 (90.9%) тэрбум төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн 3.8 (2.8 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 7. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сая.төг

Салбар	2022 I-V	2023*		2023* I-V / 2022 I-V
		I-V	Гадаад	
	тоо			хувь
Нийт дүн	**105 686.8**	**197 197.1**	**136 219.6**	**186.6**
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	95 378.1	182 105.3	133 973.4	190.9
Боловсруулах аж үйлдвэр	2 106.4	5 865.8	2 246.2	2.8 [1]
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	7 665.2	8 360.6	-	109.1
Усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	537.1	865.5	-	161.1

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 86.7 (90.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолтын салбарын борлуулалт 16.4 (23.5 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 16. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сараар, сая төгрөг



Гадаад зах зээлд 2023 оны эхний 5 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 182.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсний 180.4 тэрбум нь уул уурхай, олборлох салбарын борлуулалт байна. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад борлуулалтын 8.6 хувийг нүүрс олборлолтын салбар, 83.0 хувийг металлын хүдэр олборлолтын салбар, 8.4 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбар эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Тайлбар: Хувираа үйлдвэрлэл эрхлэгч иргэн болон ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Статистикийн хэлтэс, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал; Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал;

СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ
II. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ
II.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ
III ЭРҮҮЛ МЭНД
III.1 ЭРҮҮЛ МЭНД
III.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар
III.3 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар
IV ГЭМТ ХЭРЭГ
IV.1 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО
IV.2 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, сумаар
IV.3 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО
IV.4 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО, сумаар
V МӨНГӨ, БАНК
V.1 ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, банкуудаар, сарын эцэст
VI ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
VI.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО
VI.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА
VI.3 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сумаар
VI.4 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сумаар
VI.5 ОРОН НУТГИЙН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, эдийн засгийн салбараар
VII ҮНЭ
VII.a.1 ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС
VII.a.2 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны дундаж үнэ
VII.6 МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, сумаар, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар
VIII ХӨДӨӨ АЖ АХУЙ
VIII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, малын төрлөөр
VIII.2 МАЛ ТӨЛЛӨЛТ, сумаар
VIII.3 ТӨЛ БОЙЖИЛТ, малын төрлөөр
VIII.4 ТӨЛ БОЙЖИЛТ, сумаар
VIII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр
VIII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумаар
VIII.7 ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, малын төрлөөр
VIII.8 ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, сумаар
IX АЖ ҮЙЛДВЭР
IX.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар
IX.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар
IX.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар
IX.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар
IX.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр

II. НИЙГМИЙН ХАЛАМЖ

II.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2021 I-V		2022 I-V		2023 I-V	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Бүгд	**25 298**	**4 344.3**	**24 098**	**4 741.4**	**22 792**	**5 635.7**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	**8 988**	**2 944.3**	**6 518**	**2 831.4**	**4 499**	**2 874.5**
Нийгмийн халамжийн тэтгэвэр	**1 256**	**1 804.2**	**1 313**	**1 815.5**	**1 360**	**1 933.9**
Нийгмийн халамжийн тэтгэмж	**1 993**	**797.2**	**2 084**	**841.1**	**2 130**	**855.9**
Асаргааны тэтгэмж	**1 079**	**463.0**	**1 078**	**465.0**	**1 073**	**477.7**
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	610	240.0	608	232.6	193	78.7
Байнгын асаргаа шаардлагтай ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	217	83.6	200	79.6	619	243.5
Байнгын асаргаа шаардлагтай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	214	123.7	226	133.1	222	136.7
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	15	6.0	18	8.0	17	8.2
Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	7	3.8	5	3.7	7	4.1
Хүүхэд, төрөл садангүй ганц бие ахмад настан болон ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах	16	5.9	21	8.0	15	6.5
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	**914**	**334.2**	**1 006**	**376.1**	**1 057**	**378.2**
Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн	706	47.5	759	45.3	809	45.6
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	208	286.7	233	314.0	239	321.8
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	-	-	6	7.2	1	1.2
Гэнэтийн аюулын улмаас орон гэргүй болсон өрхөд 1 удаа олгох тэтгэмж	-	-	5	6.0	6	7.2
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр орондгүй иргэн	-	-	3	3.6	2	2.4
Нийгмийн халамжийн үйлчилгээ	**1**	1.4	**50**	**30.5**	**47**	**37.7**
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	1	1.4	50	30.5	47	37.7
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	**5 739**	**342.9**	**3 090**	**144.3**	**962**	**47.0**
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	5 739	342.9	3 090	144.3	962	47.0
Алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал	**5 236**	**698.7**	**5 347**	**704.5**	**5 568**	**722.2**
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	**4 291**	**71.8**	**4 569**	**141.9**	**4 594**	**169.4**
Алдар цолтон амхад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	**-**	**-**	**2**	**0.3**	**5**	**595.6**
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	**297**	**42.4**	**285**	**44.7**	**336**	**71.0**
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	**3 804**	**370.4**	**4 541**	**794.8**	**4 699**	**957.4**
0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	3 190	315.2	3 628	655.0	3 555	757.3
Жирэмсэн эхийн тэтгэмж	609	45.2	772	73.0	991	108.5
Ихэр хүүхдийн тэтгэмж	5	10.0	6	12.0	6	12.0
3 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд 1 удаа	-	-	135	54.8	147	79.6
Насны хишиг	**2 682**	**216.7**	**2 836**	**223.8**	**3 091**	**245.6**

III ЭРҮҮЛ МЭНД

III.1 ЭРҮҮЛ МЭНД

	Хэмжих нэгж	2021 I-V	2022 I-V	2023 I-V	2023 I-V / 2022 I-V	
					тоо	хувь
Нийт үзлэг	мян.хүн	89.2	105.9	117.2	11.3	110.7
Ор хоног	мян.хүн	35.4	55.2	55.9	0.7	101.3
